Public Disclosure Authorized

Public Disclosure Authorized

74821

Монгол Улс

Төсвийн талаарх цуврал тэмдэглэл

2013 оны төсвийн төлөв байдал

болон онцлогууд

2012 оны 12 дугаар сар

Энэхүү *Төсвийн талаарх тэмдэглэлийг* Дэлхийн банкны Зүүн Ази болон Номхон Далайн бүс хариуцсан дэд ерөнхийлөгчийн албаны харьяа Ядуурлыг Бууруулах, Эдийн Засгийн Удирдлагын салбарын нэгжээс боловсруулан гаргалаа. Тоймыг Таехуюн Лии (Багийн ахлагч, ахлагч эдийн засагч), Алтанцэцэг Шийлэгмаа (эдийн засагч) нар Чорчинг Гохын удирдлаган дор хийж гүйцэтгэв. Хуулбарыг http://www.worldbank.org.mn. татаж авч болно. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл, санал хүсэлт, асуултыг Тина Пунцаг tpuntsag@worldbank.org хаягт хандана уу.

- **Хураангуй –**

Монгол Улсын Парламент 2013 оны төсвийг 11 дүгээр сарын 15-нд баталсан бөгөөд энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (ТТБТХ) бүрэн хэрэгжиж эхэлсэн анхны төсвийн төлөвлөлтийн жил болсон онцлогтой байлаа. Уг төсөвт ТТБТХуульд зааснаар тэнцвэржүүлсэн төсвийн алдагдлыг 2 хувьд барина гэсэн заалтыг Засгийн газар хэрэгжүүлэхээр тусгагдсан. Энэ байдал нь төсвийн илүү сайн бодлогыг хэрэгжүүлэх тал дээр дэвшил авчирч байгаа боловч уг төсөв нь орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж, зарлагыг тэлэх байдалтайгаар төлөвлөсөн нь ТТБТХ-ийн зорилгыг гажуудуулж, томоохон эрсдлийг агуулж байна.

- Төсвийн нийт орлогыг 2012 оны төсвөөс 28.9 хувиар өсгөж, 7,258 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөсөн. Төсвийн нийт орлогыг өмнөх 2012 оны орлогын урьдчилсан гүйцэтгэлтэй харьцуулбал бараг 40 хувиар нэмэгдэхээр байна. 2012 оны орлого дутуу төвлөрч байгаа нөхцөл байдал болон 2009 оны Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд дахин нэмэлт хэлэлцээр хийснээс олох нэмэлт орлогыг (445 тэрбум төгрөг) оруулахаар тооцсон нь төсвийн орлогын тооцоог хэт өөдрөг болгожээ. Ирэх оны төсвийн орлогын тасалдал ДНБ-ий 6 хувьд хүрэхээр байна.

- Төсвийн нийт зарлага болон эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ нь 2012 оны төсвөөс 17.9 хувиар нэмэгдэж 7,444.6 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн байна. Үүний дийлэнх өсөлт нь хөрөнгө оруулалтын зардал огцом 44.7 хувиар өссөнтэй холбоотой. Хэдийгээр хөрөнгө оруулалтын зардал нэмэгдсэн ч хөрөнгийн засвар үйлчилгээний зардал буурсан нь шинээр болон одоогоор хийгдсэн хөрөнгө оруулалтын чанарыг баталгаажуулах тал дээр анхаарал хандуулахгүй байгааг харуулж байна. Энэ оны төсвийн зардлын төлөвлөлтөд зардлын өөр хоёр элементийг оруулаагүй байгаа нь төсвийн ерөнхий төлөв байдалд томоохон сөрөг нөлөөтэй байх талтай. Үүнд: (i) Үнийг Тогтворжуулах Хөтөлбөр (718 тэрбум төгрөг) болон (ii) Засгийн газрын гаргасан 1.5 тэрбум ам.долларын бондоос орох орлогыг ашиглах.

- Тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл ДНБ-ий 2 хувьд хүрэхээр төлөвлөгдсөн бөгөөд энэ нь ТТБТХуульд заасан хамгийн дээд хэмжээ юм. Энэ нь дэвшилттэй зүйл болохыг тэмдэглэх хэрэгтэй боловч өнөөгийн төсвийн орлогын дутагдалтай байгаа нөхцөл байдал, төсөвт нэмэгдэх дээрх хоёр зарлагыг нэмж тооцвол төсвийн алдагдал зорьсон зорилгодоо хүрэхэд төвөгтэй байна. Төсвийн нэмэгдэж байгаа зарлагын бүрэлдэхүүн хэсгээс үүдэх төсвийн үр нөлөө нь яг хэд байгаа нь одоогоор тодорхойгүй хэвээрээ байна. Бидний үзэж байгаагаар төсвийн алдагдал 6 хувьд хүрэх талтай бөгөөд түүний хэлбэлзэл нь төсвийн нэмэлт зарлагын төлөвлөгөөг хэрхэн хийж байгаагаас хамаарна.

Хэрвээ төсвөөс гадуурхи санхүүжилтийн үйл ажиллагаануудыг уг төсөвт оруулбал төсвийн алдагдал нэлээд өндөр байх болно. 2012 онд Монгол Улсын Хөгжлийн Банкаар (МУХБ) дамжуулан гаргасан төсвөөс гадуурхи санхүүжилтаас үүдэх төсвийн дарамт нь 2013 онд ДНБ-ий 4 хувиас илүү байхаар тооцоо гарч байна. Иймэрхүү төрлийн томоохон хэмжээний төсвөөс гадуурхи санхүүжилтийн үйл ажиллагаа нь ТТБТХуульд заагдсан төсвийн дүрмүүдийн үр нөлөөг ихээхэн бууруулах бөгөөд одоогийн төсөт төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас үүдэн үүсч буй хэт халалтын дарамтыг улам нэмэгдүүлэх талтай.

Сүүлийн үед хэрэгжиж буй Үнийг Тогтворжуулах хөтөлбөрт Монголбанк оролцож байгаа нь болон Засгийн газрын гаргасан бондын хөрөнгийг хэрхэн ашиглах нь тодорхойгүй байгаа зэрэг нь ТТБТХуулийг хэрэгжүүлэх тал дээр улам бүр асуудал үүсгэж байна. Засгийн газрын үнийг тогтворжуулах хөтөлбөрт Монголбанк хөнгөлөлттэй санхүүжилт үзүүлэх замаар оролцож байгаа

нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагын уламжлалт үүрэг ролиос гадуур огт өөр үзэгдэл үүсгэж байна. Энэ нь төсвөөс гадуурх өөр нэгэн санхүүжилтийн хэлбэрийг бий болгохоос өмнө амжиж Төв банк энэ байдлаасаа гарах тодорхой төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн дэлхийн санхүүгийн зах зээлд Монголын эдийн засгийг сонирхох байдал нэмэгдэж байгаа ч шинээр гарасан Засгийн газрын бондын орлогыг хэрхэн ашиглах зөв төлөвлөлтгүйгээр энэ нь томоохон төсвийн эрсдлийг үүсгэх талтай. Саяхны гаргасан бонд нь төсвөөс гадуурхи санхүүгийн суваг болж болохгүй бөгөөд бондын хөрөнгийн орлого, ашиглалтыг төсөвт зохих ёсоор тусгаж өгөх зайлшгүй шаардлагатай байгааг онцолж байна. Түүнчлэн Засгийн газар бондын орлогоор санхүүжигдэх төслүүдийг сонгож, үнэлэхдээ гадаад зээлжилтийн санхүүгийн өртөг, өөрийн орны эдийн засгийн чадавхи, хязгаарыг зэргийг тооцоход хангалттай цаг хугацаа, хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

I. Удиртгал

Монгол Улсын Их Хурал 2013 оны төсвийн төслийг 11 дүгээр сарын 15 -нд хэт тэлсэн төсвийн бодлого явагдаж байсан адармаатай үед баталсан. 2013 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжих Төсвийн Тогтвортой Байдлын Тухай Хууль (ТТБТХ)-ийн дагуу бэлтгэгдсэн анхны төсөв учир төсвийг ийнхүү баталсан нь өөрөө их чухал ач холбогдолтой зүйл боллоо. Гэвч эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэргүй байдал үргэлжилж байгаа энэ үед төсвөөс гадуурх санхүүгийн үйл ажиллагааны талаар ялангуяа тэдгээр нь Монгол Улсын Хөгжлийн Банкаар (МУХБ) дамжуулан хийгдэж байгаа нь ТТБТХуулийн төсвийн дүрмүүдийг зөрчиж болохоор байгаа нь санаа зовоосон асуудал болж байна. Өнгөрсөн жилийн хугацаанд 2012 оны төсөвт удаа дараа тодотгол хийж байсан нь төсөвт итгэх итгэлийг алдагдуулж байна. Иймд энэхүү тэмдэглэл нь 2013 оны төсөвийн үндсэн шинжүүдийг нэгтгэн төсвийн ерөнхий төлөв байдал, эрсдлүүдийг онцлон авч үзлээ.

II. Төсвийн гол шинжүүд

Төсөвт ашигласан макро эдийн засгийн таамаглалууд

2013 оны Төсөвт эдийн засгийг бодитоор 18.5 хувиар тэлж, нэрлэсэн ДНБ-ий хэмжээг 17.6 их наяд төгрөгт хүрэхээр тооцоолсон. Ирэх 2013 оны энэхүү эдийн засгийн өндөр өсөлтийг нийт экспорт 78 хувиар огцом нэмэгдэх, мөн уул уурхайн олборлолт 60 хувиар өссөнөөр бүрдүүлэхээр таамагласан. Түүнчлэн инфляцийг 2013 онд 8.1 хувьд барихаар мөнгөний бодлогын баримт бичигт тусгасан. Эдийн засгийн өсөлтийг тооцоход авч үзсэн үндсэн таамаглалуудыг ирэх оны төсөвт дараах байдлаар товч тайлбарласан байна:

- **Уул уурхайн үйлдвэрлэл болон экспорт нэмэгдэнэ.** ОТ (Оюу Толгойн уурхай) алт зэсний уурхай нь хуваарь ёсоор 2013 оны эхээр өөрийн үйлдвэрлэлээ эхлүүлнэ. 2013 онд ОТ нь 382 мянган тонн зэсийн баяжмал, 424 мянган унци алт, 802 мянган унци мөнгө үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа. ЭТТ (Эрдэнэс Таван Толгой ХХК) нь 2013 онд нүүрсний олборлолтоо хоёр дахин нэмэгдүүлэхээр төлөвлөөд байгаа.

- **Гадаад худалдааны тэнцэл сайжирна.** Нийт экспорт 78 хувиар нэмэгдэхээр байгаа бөгөөд харин импорт дөнгөж 17 хувиар өсөхөөр тооцоолсон. Дээр дурьдсанчлан, ОТ болон ЭТТ-оос гарах ашигт малтмалын үйлдвэрлэл нь экспортыг өсгөх гол хүчин зүйл болно: 2013 онд зэсийн баяжмалын экспорт 1.1 сая тонн, нүүрсний экспорт 30 сая тонн хүрнэ гэж байгаа ба үүнээс угаасан нүүрс гуравны нэгийг нь эзэлнэ. Нийт импорт 2013 онд өсөхөөр байгаа нь ЭТТ үйлдвэрлэл тэлж байгаа, мөн томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлж эхэлж байгаатай холбоотойгоор барилгын материалын болон тоног төхөөрөмжийн эрэлт нэмэгдэнэ гэж үзсэн байна.

- **Уул уурхайн бус салбаруудын өсөлтийг харьцангуй өндөр байхаар төлөвлөсөн.** Түүнчлэн хөдөө аж ахуйн салбар 4.5 хувь өсөхөөр байгаа бөгөөд үүнд 2010-2012 онуудын хооронд төл малын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор малын тоо нэмэгдэнэ, мөн улаан буудайн үйлдвэрлэл нэмэгдэхээс үүдэлтэй байна. Мах боловсруулах болон гурилын үйлдвэрлэл өргөжсөнөөр боловсруулах аж үйлдвэр 12.3 хувь өсөхөөр байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт, барилга/засварын ажил нэмэгдсэнтэй холбоотойгоор

тээвэр, худалдаа үйлчилгээний салбар 10.5 хувь өсөхөөр таамаглажээ. Бөөний болон жижиглэнгийн үйл ажиллагаа 13 хувиар нэмэгдэхээр байна.

Төсвийн ерөнхий төлөв байдал

Макро эдийн засгийн таамаглалуудын үндсэн дээр 2013 оны төсөвт төсвийн орлого болон харгалзах зардлыг дараах байдлаар тооцоолсон \Хүснэгт 1-ийг үзнэ үү\. Төсвийн бүрэлдэхүүн хэсгийн илүү дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

- **Төсвийн нийт орлого 28.9 хувиар өсч 7,258 тэрбум төгрөгт хүрэхээр төсөвлөгдсөн.** ААНОАТ, нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг зэргийг оруулсан уул уурхайн нийт орлого нийт төсвийн орлогын 24 орчим хувийг (1.7 их наяд төгрөг) эзлэхээр байна.

- **Төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх зээлийн хэмжээг 17.9 хувиар өсч 7,444.6 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөсөн.** Энэ нь голдуу хөрөнгө оруулалтын зардал 44.7 хувиар огцом нэмэгдсэнээс үүдэлтэй.

- **Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл хоёр хувьд хүрэхээр төсөвлөсөн бөгөөд Төсвийн Тогтвортой Байдлын Тухай Хуульд заасан дээд хязгаарт (ДНБ-ий хоёр хувь) нийцэж байна**. Гэвч төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлсөн мөн зарлага нэмэгдсэн зэргээс төлөвлөгдсөн төсвийн алдагдал зорилгодоо хүрэх эсэх нь нэлээд тодорхойгүй үлдэж байна. Төсвийн Тогтворжуулалтын Санд (ТТС) 169 тэрбум төгрөг хуримтлуулахаар төлөвлөсөн нь ДНБ-ий нэг хувьтай тэнцэх хэмжээ юм.

Хүснэгт 1. Батлагдсан 2013 оны төсвийн хураангуй

	2012 Тодотгол		Батлагдсан 2013		
	Тэрбум төгрөг	ДНБ-д эзлэх %	Тэрбум төгрөг	ДНБ-д эзлэх %	Өөрчлөлт %
А. НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	5,631.7	34.9%	7,258.1	41.1%	28.9%
В. НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ	5,530.3	34.3%	7,088.3	40.2%	28.2%
Татварын орлого	4,925.6	30.5%	6,461.5	36.6%	31.2%
Татварын бус орлого	602.9	3.7%	626.0	3.5%	3.8%
С. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,312.2	39.1%	7,444.6	42.2%	17.9%
УРСГАЛ ЗАРДАЛ	4,606.3	28.6%	4,906.1	27.8%	6.5%
Цалин хөлс	1,220.9	7.6%	1,406.2	8%	15.2%
Татаас шилжүүлэг	2,363.1	14.6%	2,028.4	11.5%	(14.2%)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,719.7	10.7%	2,488.9	14.1%	44.7%
Дотоодын хөрөнгө оруулалт	1,409.0	8.7%	2,008.2	11.4%	42.5%
D. ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ : B-C	(781.9)	(4.8%)	(356.3)	(2%)	
E. НИЙТ ТЭНЦЭЛ: A-C	(680.5)	(4.2%)	(186.5)	(1.1%)	
F. ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНД: E-D	101.4	0.6%	169.8	1%	

Эх үүсвэр: СЯ, 2013 төсөв, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Төсвийн орлого төлөвлөлтийн үндсэн шинжүүд

Төсвийн нийт орлого 7,258.1 тэрбум төгрөг (нэрлэсэн ДНБ-ий 41.1 хувь) буюу 2012 оны төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэлээс ойролцоогоор 40 хувиар, мөн 2012 оны

батлагдсан төсвөөс 28.9 хувиар нэмэгдэхээр төлөвлөгдсөн. Татварын орлого нь 2013 оны нийт тэнцвэржүүлсэн орлогын 91 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнд НӨАТ, ХАОАТ болон бусад татвар, хураамж нь засгийн газрын орлогын гол эх үүсвэр болж байна. Уул уурхайн орлого (1.7 их наяд төгрөг) нь 62 хувиар өсөхөөр тооцоологдсон бөгөөд энэ нь ОТ болон ТТ уурхайнуудаас орох уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэхтэй холбоотой (үүнд 2009 онд зурагдсан ОТ хөрөнгө оруулалтын Гэрээнд дахин хэлэлцээр хийж нэмэлт орлого оруулахаар тооцсон). Уул уурхайн бус орлого нь нийт орлогын 76 хувь байхаар байгаа бөгөөд энэ нь 21 хувиар өсөхөөр тооцоологдсон нь эдийн засгийг тэлнэ гэж үзсэнтэй холбоотой. Зураг 1 нь нийт татварын орлогын бүрэлдэхүүн хэсгийг харуулсан, харин Зураг 2 нь уул уурхайн болон уул уурхайн бус орлогын хандлагыг харууллаа.

Зураг 1. Татварын орлогын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд



Зураг 2. Нийт орлого болон уул уурхайн орлогын төсөөлөл: 2013 төсөв (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Сангийн Яам, 2013 оны төсөв, 2013 оны төсвийн баримт бичигт үндэслэсэн Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

ААНОАТ, нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг зэргийг оролцуулсан нийт уул уурхайн орлого нь нийт орлогын 24 орчим хувийг (1.7 их наяд төгрөг) эзлэхээр байна. Уул уурхайгаас орох орлого нь 2013 онд 2012 оныхоос бараг 62 хувиар өсөхөөр (1 их наяд төгрөг орчимд) төлөвлөгдсөн нь ОТ гэрээнд дахин хэлэлцээр хийх болон алт, нүүрсний экспорт нэмэгдэнэ гэж үзсэнтэй холбоотой. Хүснэгт 2-т Сангийн Яамны тооцоолсон уул уурхайн орлогын төсөөллийг харуулсан.

Хүснэгт 2. Уул уурхайн татварын орлогын бүрэлдэхүүн хэсэг: 2013 Төсөв

Бүтээгдэхүүнүүд	Татварын эх үүсвэрүүд (тэрбум төгрөг)						Нийт
	ААНОАТ	Нөөц ашигласны төлбөр	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	Ногдол ашиг	Гаалийн татвар	Бусад	
Алт	15.95	75.1	20.6	-	-	9.9	121.5
Нүүрс	72.9	188.9	74.6	16.30	52.2	61.27	466.1
Зэс	44.1	115.2	153.6	66.0	79.0	0.95	457.9
Бусад	26.6	76.9	48.9	-	10.58	7.22	170.3
Дэд-Нийт уул уурхайн орлого	174.1	461.2	298.5	82.30	63.7	177.3	1,252.7
ОТ-с олох нэмэлт орлого	224.5	-	221.3	-	-	-	445.8
Нийт уул уурхайн орлого	398.6	461.2	519.6	82.3	63.7	177.3	1,702.9

Тэмдэглэл: Дэд-нийт үул үүрхайн орлого нь Засгийн газрын ОТ үүрхайгаас нэмж олохоор тооцсон байгаа нэмэлт орлогыг хассан.
Засгийн газар нь үул үүрхайн орлогын тооцоонд үул үүрхайн салбараас авах НӨАТ-горуулж тооцдоггүй..
Эх үүсвэр: Сангийн Яам

Уул уурхайн орлогын энэхүү төсөөлөл нь гол нэрийн бүтээгдэхүүний үнэ болон хэмжээний таамаглалаас ихээхэн хамаардаг. ТТБТХуульд Засгийн газрыг төсвийн орлогын гурав болон түүнээс дээш хувийг бүрдүүлж буй гол бүтээгдэхүүнүүдийг тодорхойлон, уг ТТБТХуульд[1] заасан тусгай дүрмийн дагуу тэдгээрийн тэнцвэржүүлсэн үнүүдийг тооцоолж байхаар заасан байдаг. Хүснэгт 3 нь 2013 оны төсөвт гол бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнүүдийг тухайн дүрмийн дагуу хэрхэн таамагласныг (жишээ нь нэг тонн зэсийн үнэ 6,328 ам.доллар, нэг тонн угаасан нүүрсний үнэ нь 131.5 ам.доллар) харууллаа. Засгийн газрын тооцоолсон гол нэрийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнүүд нь 2012 оны төсвийн тодотгол оруулсан үеийн тэнцвэржүүлсэн үнүүдтэй харьцуулбал ТТБТХуулийн төсвийн дүрмийг дагаж буурсан. Гол нэрийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнүүд нь 2012 оны нэмэлт өөрчлөлт орсон төсөвт нэг тонн зэсийн үнэ 7,970 ам.доллар, нэг тонн боловсруулсан нүүрсний үнэ нь 166.6 ам.доллар, нэг тонн кокжсон нүүрсний үнэ 102.6 ам.доллар, мөн нэг тонн чулуун нүүрсний үнийг 72.4 ам.долларт байхаар авч байсан. Лондонгийн Металын Биржэд нэг тонн зэсийн үнэ 11 дүгээр сар болон 12 дугаар сарын хувьд дунджаар 7,700 ам.долларт эргэлдэж байсан байна. Энэхүү төсөөллөөр авч үзвэл 2013 онд нийт экспорт 78 хувиар (өмнөх оны мөн үетэй харьцуулбал), харин нийт импорт 17 (өмнөх оны мөн үетэй харьцуулбал) хувиар өсөхөөр төсөөлөгдөж байна.

.

Хүснэгт 3. 2013 оны төсвийн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээний төсөөлөл

	Хэмжээ	Тэнцвэржүүлсэн үнэ	Зах зээлийн үнэ
Зэс	945 мянган тонн	Нэг тонн /6328.9 ам.доллар	Нэг тонн /8,152 ам.доллар
Боловсруулсан нүүрс	5.8 сая тонн	Нэг тонн /131.5 ам.доллар	Нэг тонн / 161.2 ам.доллар
Кокжсон нүүрс(5500 ккал дээш)	14.4 сая тонн	Нэг тонн / 80.2 ам.доллар	Нэг тонн / 96.7 ам.доллар
Чулуун нүүрс (4000-5500 ккал)	5.7 сая тонн	Нэг тонн / 65.5 ам.доллар	Нэг тонн / 83.17 ам.доллар

Эх үүсвэр: Сангийн яам, 2013 оны төсөв

2013 оны төсөвт хувьчлалын орлогоор 20 тэрбум төгрөгийг олохоор төлөвлөсөн бөгөөд үүнийг орлого зарлагын шугамнаас дээгүүр буюу татварын бус орлогын ангилалд оруулж бүртгэсэн нь өмнөх төсвүүдийнхээс өөр бүртгэл болсон. Өмнөх жилийн төсвүүдэд хувьчлалын орлогыг төсвийн санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг болгон дээрх шугамнаас доор гаргаж бүртгэдэг байсан бөгөөд энэ нь 2011 оны Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Гарын Авлагад (ОУВС) заасны дагуу хийгддэг байсан бөгөөд уг гарын авлагаар хувьчлалын орлого нь санхүүжүүлэх зүйл анги гэж ангилагддаг. Хэдийгээр хувьчлалын орлогын нийт дүн нь харьцангуй их биш боловч хувьчлалын орлогыг санхүүжилтийн нэг хэлбэр бус харин татварын бус орлого гэж үзэн бүртгэх нь тэр хэмжээгээр төсвийн алдагдлыг бууруулна гэдгийг анхаарах ёстой.

2013 оны төсөвт авч үзсэн орлогын таамаглал нь хэтэрхий өөдрөг болсон харагдаж байна. 1-11 дүгээр саруудын төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээлэл дээр үндэслэн Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцсон 2012 оны жилийн эцсийн орлогын урьдчилсан гүйцэтгэлтэй

[1] ТТБТХуулийн дагуу, гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн тэнцвэржүүлсэн үнүүд нь (i) тухайн бүтээгдэхүүний сүүлийн 12 жилийн дундаж үнэ болон (ii) тухайн жилийг оруулан тооцсон ирэх дөрвөн жилийн төсөөллийн үнийн дундаж

харьцуулахад 2013 оны төсвийн төсөөлөл бараг 40 хувиар өндөр байхаар байна. (2012 оны урьдчилсан гүйцэтгэлийн тооцооллын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хайрцаг 1-ээс харна уу). Төсөвт мөн ОТ хөрөнгө оруулалтын гэрээнд дахин хэлэлцээр хийн нэмэлт орлого оруулахаар тусгасан нь маргаантай байна. Ийм нөхцөл байдалд, (2012 оны 11 сар) 2013 оны төсвийн орлогын тасалдал нь ДНБ-ий 6 хувьд хүрч болзошгүй байгааг ОУВСангийн мэргэжилтнүүдийн тайлан харуулсан.

- **Дэлхийн эдийн засгийн байдал тааламжгүй байгаа, Хятад улсын эдийн засгийн сэргэлт тодорхойгүй байгаа энэ нөхцөл байдалд эдийн засгийн өсөлтийг 18.5 хувь байхаар таамагласан нь мөн хэтэрхий өөдрөг байх талтай.** 2012 оны сүүлийн хагаст Монгол улсын эдийн засгийн өсөлтийн хурд удааширсанаас 2013 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалаа Дэлхийн банк 16.2 хувь, ОУВС нь 16.8 хувь байхаар тус тус бууруулсан. Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал Хятад улсын эдийн засгийн гүйцэтгэлээс ихээхэн хамааралтай байдаг: Хятад улс 2012 оны эхний 8 сарын байдлаар нийт экспортын 93.7 хувийг эзэлж байна. Мөн Хятад улсын эдийн засгийн өсөлт 2012 оны туршид аажмаар саарч, эхний улиралд 8.1 хувь байснаа гуравдугаар улиралд 7.4 хувьд хүрсэн нь сүүлийн 14 улирлын хувьд хамгийн бага түвшинд хүрсэн байна. Хятадын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын талаархи сүүлийн сарын тоо мэдээнээс харахад улсын салбарын хүчтэй хөрөнгө оруулалтын улмаас Хятад улс сэргэх байдал ажиглагдаж байна. Гэвч түүний худалдааны гол түншүүд болох Европын Холбоо болон АНУлсуудад эдийн засаг буурах эрсдэл байгаа нөхцөлд Хятадын эдийн засгийн дахин сэргэлт тодорхойгүй хэвээр үлдэж байна.

- **Төсвийн орлогын тооцоонд нь 2009 оны ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээнд дахин хэлэлцээр хийн нэмэлт орлого төвлөрүүлэх төлөвлөгөө тусгагдсан бөгөөд тэрхүү нэмэлт орлого нь 445.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.5 хувьд хүрэхээр хэмжээтэй байна** (Хүснэгт 2). Дахин хэлэлцээрийн үр дүнд орох орлогын нэмэлт эх үүсвэрийн тэн хагас болох өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрын орлого буюу 221.3 тэрбум төгрөгийг 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээнд 5 хувь байхаар тусгагдсан нөөц ашигласны төлбөрийг бүтээгдэхүүний үнийн түвшнээс хамааран 20 хувь хүртэл өсгөж нөөц ашигласны төлбөр болгон авахаар тооцжээ. Үлдсэн 224.5 тэрбум төгрөгийг ААНОАТ (аж ахуйн нэгжийн орлогын албан татвар) байдлаар авахаар бүртгэсэн. Гэвч ААНОАТ-ын орлогын ямар эх үүсвэр нь нэмэлт эх үүсвэр байдлаар нэмэгдэх эсэх нь тодорхойгүй хэвээрээ байна[2]. Энэ нь Засгийн газар Нидерланд улстай хийсэн Давхар Татварын Гэрээгээ хүчингүй болгохоор зарласнаас үүдэн тэрхүү гэрээнд байсан ААНОАТ-ын зарим хөнгөлөлт, чөлөөлөлтийг байхгүй болгосноор олох нэмэлт орлого гэсэн дотоод ойролцоо тооцоолол байж болохыг харуулж байна. Гэвч энэхүү нэмэлт орлого нь анхны хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төлөх ёстой Оюу Толгойн татварын дүнгээс бараг гурав дахин илүү дүнтэй байгаагаас Оюу Толгой компани Засгийн газрын энэхүү төлөвлөгөөг хүлээн зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй хэвээрээ үлдэж байна. Цаашилбал, ОТ-д дахин хэлэлцээр хийх тухай асуудлыг тойрсон тодорхой бус байдал нь хөрөнгө оруулалтын гэрээг

[2] Төсөвт дараах тайлбарыг өгчээ: “Улсын Их Хурлаас Засгийн Газарт хөрөнгө оруулалтын Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар Оюу Толгойгоос нөөц ашигласны төлбөр авах мөн ААНОАТатварт зарим хөнгөлөлт чөлөөлөлтийг бууруулах замаар нийтдээ 445 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлнэ” (Дэлхийн банкны орчуулга)

мухардалд оруулж, ОТ уурхайн үйлдвэрлэл хойшлогдон, улмаар орлогын төсөөллийг хүнд байдалд оруулах өөр нэг эрсдэл үүсгэж байх талтай.

Зардлын төлөвлөлтийн үндсэн шинжүүд

2013 оны төсөвт өмнөх 2012 онтой харьцуулбал нийт зарлага болон эргэн төлөгдөх цэвэр зээлийн хэмжээг 17.9 хувиар нэмэгдэхээр тооцсон. Нийт зарлага болон эргэн төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 7,444 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь 2013 онд ДНБ-ий 42.2 хувьтай тэнцэхээр байна. Зардал хоёр оронтой тоогоор ийнхүү нэмэгдэж байгаа нь дотоодын хөрөнгө оруулалт 42.5 хувиар нэмэгдэж нийт зардлын бараг 30 хувьд хүрэхээр байгаатай холбоотой.

Зураг 3. Нийт зарлагын гол бүрэлдэхүүн хэсгүүд : 2013 оны төсөв



Зураг 4. Зардлын гол бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлт: 2013 он болон 2012 оны төсөв (%)



Эх үүсвэр: Сангийн яам, 2013 оны төсөв, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Урсгал зардал 2013 онд 6.5 хувиар нэмэгдэхээр байгаа бөгөөд энэ нь 2012 оны тодотголд орсон 28 хувиар өсөхөөр тооцоолсонтой харьцуулахад ихээхэн бууралт юм. Урсгал зардал харьцангуй бага хэмжээгээр нэмэгдэж байгаа нь урсгал зардлын хоёр томоохон зүйл ангийн өсөлт удааширсан эсвэл буурсантай холбоотой байна: (i) цалин хөлс өмнөх 2012 оны төсөвт огцом 53 хувь өссөнтэй харьцуулбал зөвхөн 15.2 хувиар өснө, мөн (ii) шилжүүлэг 17 хувиар буурна. Өрийн үйлчилгээний төлбөр огцом буюу 162 хувиар нэмэгдсэн байна.

- **Засгийн газрын цалин хөлсний зардал өмнөх 2012 оны төсвийн тодотголд 50–аас дээш хувиар өссөнөө 15.2 хувь болж өсөхөөр өсөлтийн хурдац огцом хэмжээгээр буурсан.** Төрийн албаны цалин хөлсийг өрсөлдөхүйц түвшинд барих зорилгоор Засгийн газар цалинг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлсээр ирсэн боловч төсвийн болон инфляцийн дарамт ихтэй ийм нөхцөл байдалд төсөвт бага дарамт үзүүлэх хувилбарыг авч үзэх шаардлагатай байна. Дэлхийн банкны саяхны тайлангаас[3] харахад, төрийн албаны цалин сүүлийн таван

[3] Дэлхийн банк, Бодлогын тэмдэглэл, 2012 оны 10 сар, Монгол Улс: Төрийн Үйлчилгээний Шинэчлэлийн Хувилбарууд

жилд бүхэлдээ тогтмол 15-30 хувиар нэмэгдэж ирсэн боловч хувийн салбарын цалингийн өндөр өсөлтийн хурдтай зэрэгцэж чадаагүй байна. Мөн нэрлэсэн цалингийн хэмжээ 2003 оноос хойш 7 дахин нэмэгдсэн бөгөөд энэ нь төсвийн том дарамт болсон. Үүнээс гадна, ОУВСангийн саяхны судалгаанаас[4] харахад, засгийн газрын цалин өсөх нь зарлагын голлох үзүүлэлтүүдийн дотроос инфляцид хамгийн том нөлөөлөх хүчин зүйл болдогийг харуулсан бөгөөд 2012 онд цалинг огцом 50 хувиас дээш нэмсэн нь инфляцийг 5 хувийн пунктээр нэмэгдүүлэхэд хүргэсэн гэжээ. Эдгээр судалгааны үр дүнгүүдээс үзэхэд, Засгийн газар одоогийн нийтэд нь хавтгайруулан цалинг өсгөдөг тогтолцоог халж ажиллагсадын төрөл бүрийн ангилал зэрэглэлд тохируулан зах зээлд суурилсан цалингийн илүү зорилтот урамшуулал бүхий уян хатан цалин хөлсний бодлогыг боловсруулах шаардлага гарч байна.

- **Засгийн газрын зээлийн үлдэгдлээс тооцох хүүгийн төлбөр нь 153 тэрбум төгрөгөөс 398 тэрбум төгрөгт хүрч 162 хувиар нэмэгдэхээр байна.** 2012 оны 11 сарын 28-нд гаргасан 1.5 тэрбум ам.долларын засгийн газрын бондын өрийн үйлчилгээнд 140 тэрбум төгрөг төлөвлөсөн бөгөөд энэхүү бонд гаргалт нь хоёр хэсгээс бүрдэнэ: таван жилийн хугацаатай 0.5 тэрбум ам.долларын бондыг 4.125 хувийн хүүтэй, мөн 10 жилийн хугацаатай 1 тэрбум ам.долларын бондыг 5.125 хувийн хүүтэй байна. МУХБанкны зээлсэн гадаад зээлийн (580 сая ам.доллар) хүүгийн төлбөрт 97.5 тэрбум төгрөг төлөгдөхөөр байна.

- **Хүний Хөгжлийн Сангаас (ХХС) олгодог бэлэн мөнгөний шилжүүлгийн хэмжээ 2.2 их наяд байснаа 2013 онд 1.8 их наяд хүрч 17.9 хувиар огцом буурахаар төлөвлөж байна.** Шилжүүлгүүдэд орон нутгийн шилжүүлэг, нийгмийн даатгалын шимтгэл, болон ХХС-н шилжүүлгүүд багтаж байгаа нь 2013 онд нийлээд нийт зарлагын 24.8 хувийг бүрдүүлэхээр байна. ХХСангаас олгох нийт шилжүүлэг 2013 онд 866 тэрбум төгрөгөөс 284 тэрбум төгрөг болж 67 хувиар буурахаар байгаа ба энэ нь нийтийг хамарсан шилжүүлгийн схемийг Хүүхдийн Мөнгө[5]ний Шилжүүлгээр сольж байгаатай холбоотой. ХХС-н төсөв нь шинээр Хүүхдийн Мөнгөн Шилжүүлэг (240 тэрбум төгрөг) болон 2010-2012 онуудад зохион байгуулалтын шинж чанартай асуудлаас үүдэн бэлэн мөнгөө авч чадаагүй хүмүүст[6] олгохоор төлөвлөсөн мөнгө тараах хөтөлбөрийн үлдэгдэл болох 32 тэрбум төгрөгийг оруулсан байна. ХХС нь Хүний Хөгжлийн Сангийн Тухай Хуулийн дагуу дараах орлогыг авна: (i) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр[7] (ii) ногдол ашиг, (iii) ОТ дахин хэлэлцээрээс орох өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр. Хүснэгт 4 нь ХХС Төсвийн бүрэлдэхүүн хэсгийг харуулаа.

[4] Олон Улсын Валютын Сан, Ажлын Тайлан, WP/12/192, 2012 оны 7 дугаар сар, Монгол дахь Инфляцийн Динамик

[5] Хүүхдийн мөнгө хөтөлбөр нь 0-18 насны хүүхэд тус бүрд сар бүр 20,000 төгрөг олгохоор төлөвлөсөн.

[6] Нийтийг хамарсан шилжүүлэгийн хөтөлбөрт, иргэн бүрт анх 1 сая төгрөгийг тараахаар төлөвлөж байсан. Энэ хөтөлбөрийн хэсэг болгож, 500,000 төгрөгийг 2010-2012 онуудын туршид хүн бүрт тараасан. Харин 2013 онд захиргааны шинжтэй шалтгаанаас үүдэн 500,000 төгрөгийг хүртээгүй хүмүүст зориулан 32 тэрбум төгрөгийг хуваарилсан.

[7] Нэгдсэн Төсвийн тухай хуулийн дагуу уул уурхайгаас олох нөөц ашигласны төлбөр нь дараах дүрмээр хуваарилагдана: 70 хувь нь ХХС, 25 хувь нь Орон нутгийн төсөвь, 5 хувь нь Орон Нутгийн Хөгжлийн Сан.

Хүснэгт 4. 2013 Хүний хөгжлийн сан (тэрбум төгрөг)

	Зарлага				2013 Орлого
	2010	2011	2012	2013	
Бэлэн мөнгөний шилжүүлэг	305.0	721.3	751.3	272	Нөөц ашигласны төлбөр 396.4
Эрүүл мэндийн даатгалын шимэтгэл	10.9	15.8	12.2	12.2	Ногдол ашиг 70
Бусад	0	66.8	102.6	0	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр 155
Нийт	315.9	803.9	866.0	284.2	621.4

Эх үүсвэр: Сангийн яам, 2013 оны төсөв, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Нийт хөрөнгө оруулалтын зардлыг 44.7 хувиар нэмэгдэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь дотоодын хөрөнгө оруулалт 42.5 хувиар огцом нэмэгдэхтэй холбоотой. Дотоодын хөрөнгө оруулалтын зардал 2013 онд (2,488 тэрбум төгрөг) 2011 оны түвшнээс бараг хоёр дахин их байгаа бөгөөд 2011 онд дотоодын хөрөнгийн зардлын өсөлт 20 хувь байснаа 2013 онд 27 хувь болсон байна. Хэдийгээр хөрөнгийн зардал нэмэгдэж байгаа ч хөрөнгийн засвар үйлчилгээний зардал долоон хувиар буурч байгаа нь шинээр хийгдэх болон хуучин байгаа хөрөнгө оруулалтын чанарыг хэвээр хадгалах тал асуудал шинээр үүсч байна.

- **Дотоодын хөрөнгө оруулалтын зардал ихээхэн хэмжээгээр нэмэгдэж байгаа нь төсвийн үр ашигтай, үр дүнтэй төлөвлөлт болон хэрэгжилтийн ач холбогдлыг бууруулах талтай байна.** Нэгдсэн Төсвийн Тухай Хууль нь (НТТХ) төслийг бэлтгэх, үнэлэх тал дээр зохицуулалтыг бэхжүүлэх, болон төлөвлөлт болон хөрөнгийн төсвийн хоорондох зохицуулалтыг сайжруулахад томоохон алхам болсон. Гэвч НТТХуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн ажил хийгдэх хэрэгтэй. Эдийн Засгийн Хөгжлийн Яам (ЭЗХЯ) болон Сангийн Яамны (СЯ) одоогийн чадавхи, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн ч дээрх яамдын хооронд хөрөнгийн болон урсгал зардлуудад тавих үүрэг хариуцлагуудыг хуваасан нь төслийг үр ашигтай бэлтгэх болон хяналт тавихад саад учруулж байх талтай. Засгийн газрын одоогийн хязгаарлагдмал чадавхид тохируулан байгаа нөөцөө хамгийн үр ашигтай ашиглах илүү амьдралд ойрхон, бодитой аргыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна, тухайлбал, СЯ нь жижиг төслүүдийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ЭЗХЯ нь томоохон

Зураг 5. Шинэ хөрөнгө оруулалт болон засварын үйлчилгээний өсөлт

Эх үүсвэр: Сангийн яам, 2013 оны төсөв, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

төслүүдийг хариуцах гэх мэт. Дэлхийн банкны саяхны[8] судалгаа нь Монгол Улсад улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрхэн сайжруулах талаар илүү гүнзгий хэлэлцүүлэгийг хийж, олон төрлийн бодлогын зөвлөмжүүдийг гаргасан.

- **Засвар үйлчилгээний зардал буурсан нь (долоон хувиар буурсан) хөрөнгийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээнд зориулагдах нөөцийг дутуу хувиарласан байх асуудлыг бий болгож байна.** Дэлхийн Банкны хийсэн Дэд Бүтцийн Судалгаанаас харахад хөрөнгийн засвар үйлчилгээг хайхрахгүй байх нь хямралд хүргэх талтай, ялангуяа эрчим хүч, замын үйлчилгээнд энэ нь их чухал байдагийг харуулсан. Жишээ нь, цахилгаан эрчим хүчний салбарт зайлшгүй шаардагдах хөрөнгийн засвар үйлчилгээний өртөг нь дангаараа ДНБ-ий бараг хоёр хувьд хүрдэг бөгөөд улсын хэмжээнд хучилттай замын 60 хувийг засах, шинэчлэх шаардлагатай байгаа бөгөөд үүний өртөг нь ойролцоогоор ДНБ-ий долоо орчим хувьд хүрэхээр тооцоо гаргасан байна. Гэвч 2013 оны төсөв нь шинэ хөрөнгө оруулалтын төсөлд ихээхэн чухал ач холбогдол өгсөн бөгөөд хөрөнгийн засварын зардал болон шинэ хөрөнгө оруулалтын харьцаа сүүлийн таван жилд буурсаар байна. Засвар үйлчилгээ, арчилгааг орхигдуулах нь төсвийн болон эдийн засгийн хувьд аль аль талдаа алдагдалтай бөгөөд одоогийн байгаа дэд бүтцийн ашиглалтын хугацааг багасгаж, ирээдүйд түүний шинэчлэлийн өртгийг нэмэгдүүлснээр төсөвт илүү хүнд дарамт үүсгэнэ. Хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдэж байгаа энэ үед хөрөнгийн засвар үйлчилгээ болон арчилгаанд зохих хэмжээний хөрөнгө мөнгө хувиарлах нь одоогийн байгаа хөрөнгийн үйл ажиллагааг хэвийн хангах болон зохих үр ашгийг нь хүртэхэд голлох үүрэгтэй юм.

2013 оны төсөвт саяхан зарласан Үнийг Тогтворжуулах Хөтөлбөрийг оруулаагүй байна. Энэхүү хөтөлбөрийн өртөг нь дараагийн гурван жилд 718 тэрбум төгрөг (2013 оны ДНБ-ий 4 хувь) байхаар байна. Засгийн газрын боловсруулсан энэхүү хөтөлбөр нь хүнсний хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүнүүд, түлш, импортоор орж ирдэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүнүүд болон орон сууцны үнийг тогтворжуулах зорилготой. Засгийн газартай хийсэн гэрээний дагуу Төв банк нь Засгийн газрыг бонд гаргаж Төв банкны зээлийг солих хүртэлх хугацаанд арилжааны банкуудаар дамжуулан, сонгосон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчдэд түр хугацаагаар хөнгөлөлттэй зээлийг олгох юм. Засгийн газрын энэхүү хөтөлбөрийн зорилго нь инфляцийг хөөргөдөж буй нийлүүлэлтийн талын хүчин зүйлийг шийдэхэд чухал алхам боловч уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх схем нь хэд хэдэн том асуудлыг өөртөө агуулж байна:

- **Үнийг тогтворжуулах хөтөлбөр нь Төв банкыг төсвийн үйл ажиллагаанд тухайлбал хяналт шалгалт болон хэрэгжилтийг хянахад хэт их хэмжээгээр оролцуулж байна.** Энэ хөтөлбөр нь нийлүүлэлтийн талын саадыг даван гарахад, тухайлбал тээвэрлэлт, стратегийн бүтээгдэхүүнийг хуваарилах болон хадгалахад хэрэглэгддэг Засгийн газруудын ашигладаг түгээмэл үйл ажиллагааны нэг юм. Иймд Төв банк нь Засгийн газартай гэрээ байгуулан оролцох нь төв банкны уламжлалт үүргээс нэлээд хол давсан зүйл байх нь тодорхой.

- **Хөтөлбөрийг санхүүжүүлж буй арга механизмуудын нэг нь төв банкны олгосон шинэ зээл бөгөөд энэ нь зах зээлд ДНБ-ий 4 хувьтай тэнцэх мөнгийг шинээр нийлүүлж буй явдал юм.** Энэ нь инфляцийг тогтоон барихад чиглэгдсэн хэрнээ өөрөө инфляцийг улам өдөөсөн арга хэмжээ юм. Одоогоор Төв банкинд энэхүү шинэ мөнгөний нийлүүлэлтийг

[8] Дэлхийн Банк, 2012 оны 10 дугаар сар, Дэд Бүтэц өсөн нэмэгдэж байгаатай уялдаж Улсын Хөрөнгө оруулалтыг Сайжруулах

стерилизаци хийх төлөвлөгөө байхгүй байна. Хэдийгээр засгийн газар шинээр бонд гаргаж санхүүжүүлтэл энэхүү мөнгөний шинэ нийлүүлэлт нь түр зуурын арга хэмжээ байх юм шиг боловч, Төв банк засгийн газрын тэрхүү бондыг нь худалдан авах замаар уг хөтөлбөрийн гол санхүүжүүлэгч хэвээрээ үлдэх магадлал өндөр байна. Харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу, Засгийн газрын бондын орлогоор төв банкны зээл солигдмогц, төв банк энэ хөтөлбөрийг санхүүжүүлэхгүй байх тал дээр Засгийн Газар болон Төв банк аль аль нь хичээх шаардлагатай.

- **Уг үнийг тогтворжуулах хөтөлбөрийн өртөгийг төсөвт дараах зорилгоор зохих ёсоор тусгах шаардлагатай: (i) төсвийн дарамт үүсгэж байгаа бодлогын бүхий л үйл ажиллагааг багтаасан төсвийн нэгдмэл төлөвлөгөөтэй байх; (ii) төв банкыг төсвөөс гадуурхи санхүүжилт хийдэг өөр нэг суваг болгон ашиглах боломжийг огт байхгүй болгох**. Хэдийгээр уг хөтөлбөр нь гурван жилийн хугацаатайгаар хэрэгжих төлөвлөгөөтэй боловч Төв банкнаас гарах ихэнх зээл нь 2013 гэхэд гарч дууссан байх талтай.

Төсвийн Санхүүжилтийн Төлөвлөгөө

2013 оны Төсөвт ТТБТХуулийн хязгаарт тааруулан тэнцвэржүүлсэн төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувьд барихаар төлөвлөсөн. Төсөвт санхүүжилтийн хэрэгцээний 55 хувийг дотоодын бонд гаргах болон зээлж, мөн 45 хувийг гадаад санхүүжилтээр нөхөхөөр төлөвлөсөн. Шинээр гаргах дотоодын нийт бондын хэмжээ нь 2013 онд 812 тэрбум төгрөг байх бөгөөд 421.8 тэрбум төгрөгийг одоогийн үлдэгдэл бондын үндсэн төлбөрийг эргэн төлөхөд хэрэглэнэ. Төсөвт 169.7 тэрбум төгрөгийн уул уурхайн орлогыг Төсвийн Тогтворжуулалтын Санд (ТТС) төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь ДНБ-ий 1 хувьтай тэнцэнэ. ТТСанд төвлөрөх уул уурхайн орлогын эх үүсвэр нь ААНОАТ (38 тэрбум төгрөг), нөөц ашигласны төлбөр (55.3 тэрбум төгрөг) болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрүүдээс (76.4 тэрбум төгрөг) бүрдэнэ.

Санхүүжилтийн төлөвлөгөөнд саяхан гаргасан 1.5 тэрбум ам.долларын бондыг нэмж тусгах хэрэгтэй бөгөөд гадаад санхүүжилтийн шинэ үүсвэрүүдийг төсвийн шугамны доод талд бүртгэх ёстой, учир нь энэ нь засгийн газрын санхүүгийн үйл ажиллагаа юм. Саяхны 1.5 тэрбум ам.долларын бонд нь 2013 оны ДНБ-ий 11-12 хувиас илүү хувьтай тэнцэх ихээхэн хэмжээний засгийн газрын зээллэг гэгдэх бөгөөд цаашдаа төсөвт томоохон ачаалал болох юм. 2013 оны бадлагдсан төсөвт энэхүү шинээр гаргасан бондын хүүгийн төлбөрийг л зөвхөн тусгасан. Энэхүү бондын 2013 оны төсвийн алдагдалд хэр нөлөө үзүүлэх нь Засгийн газар бондын орлогыг хэрхэн ашиглахаас ихээхэн хамаарна: (i) Хэрвээ Засгийн газар уг орлогыг Монголбанкин дахь дансандаа хадгалбал энэ нь шугамнаас доогуурх үйл ажиллагаа болох бөгөөд төсвийн алдагдалд нөлөөлөхгүй; (ii) харин хэрвээ Засгийн газар энэхүү орлогыг дэд бүтцийн хөрөнгө оруулалт зэрэг засгийн газрын хөтөлбөрийг санхүүжүүлэхээр зарцуулах бол орлогын ашиглалтыг төсвийн шугамнаас дээш эсвэл хөрөнгө оруулалтын зардал (хэрвээ засгийн газрын дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхээр шууд хэрэглэгдэх бол) эсвэл эргэн төлөгдөх цэвэр зээлийн бүрэлдэхүүн хэсэг (хэрвээ МУХБанкинд зээлбэл) болгон бүртгэх ёстой. Сүүлийн тохиолдолд, төсвийн алдагдал энэ хэмжээгээр нэмэгдэх бөгөөд энэ нь ТТБТХуулийн тэнцвэржүүлсэн төсвийн алдагдлын хязгаарыг зөрчих томоохон эрсдлийг үүсгэх юм.

III. Төсвийн төлөв байдал болон эрсдэл

ТТБТХуулийн 2 хувийн хязгаарт төсөв хүрэх амлалттай байгаа боловч төсвийн зорилтууд нь биелэхэд төвөгтэй байна. 2012 оны орлогын дутагдалтай байдал болон 2009 оны ОТ (Оюу Толгойн уурхайн) хөрөнгө оруулалтын гэрээнээс хүлээгдэж байгаа маргаантай нэмэлт орлого зэргийг оруулан тооцсноос нийт орлогын төсөөлөл хэт өндрөөр төсөвлөгдсөн. Төсвийн орлогын тасалдал ДНБ-ий 6 хувьд хүрч болох талтай[9]. Одоогийн төсвийн зарлагын төлөвлөлтөд хоёр шинэ төрлийн зарлагын элементүүдийг оруулаагүй бөгөөд эдгээр нь төсвийн төлөв байдалд томоохон сөрөг үр дагавартай байх талтай: (i) Үнийг Тогтворжуулах Хөтөлбөр (718 тэрбум төгрөг) болон (ii) 1.5 тэрбум ам.долларын засгийн газрын бондын орлогыг ашиглах. Эдгээр нэмэлт зарлагын бүрэлдэхүүн хэсгүүдээс үүсэх төсөвт үзүүлэх нөлөөлөл нь энэ үед тодорхойгүй хэвээр үлдэж байна. Гэвч бид төсвийн алдагдлыг 6 гаран хувьд хүрнэ гэж үзэж байгаа бөгөөд түүнээс хэлбэлзэх хэлбэлзэл нь энэхүү нэмэлт зарлагыг хэрхэн зарахаас ихээхэн хамаарахаар байна. (Шигтгээ 1-ээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг харна уу)

Төсөвт төсвөөс гадуурх санхүүжилтийн үйл ажиллагааг оруулж тооцвол төсвийн алдагдал хамаагүй өндөр байхаар байна. Монгол Улсын Хөгжлийн Банкнаас томоохон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор 5 тэрбум ам.долларын зээл авахаар төлөвлөж байгаа нь төсвийн болон макро эдийн засгийн тогтвортой байдалд томоохон асуудал үүсгэхээр байна. ТТБТХуулийн дүрэмд хамрагдахгүй байгаа учраас, МУХБ нь дэд бүтцийн төслүүдийг төрийн санхүүжилтээр санхүүжүүлэх гол эх үүсвэр нь болоод байна. Өртөгөө нөхөх чадвар багатай төслүүдийг санхүүжүүлбэл МУХБанкны үйл ажиллагаа нь эцсийн дүндээ төсвөөс л эргээд эргэн төлөгдөх бөгөөд энэ нь эцэстээ төсөвт ихээхэн хэмжээний дарамт авчирах юм. Иймд МУХБанкны үйл ажиллагаа нь ТТБТХуулийн дүрмүүдэд зохих ёсоор хамрагдаж захирагдах ёстой юм. 2012 онд хийгдсэн тооцоо ёсоор бол Монгол Улсын Хөгжлийн Банкаар дамжсан төсвийн гадуурх санхүүжилтийн төсвийн дарамт нь 2013 онд ДНБ-ий 4 хувиас илүүд хүрэхээр[10] байна.

Үнийг Тогтворжуулах Хөтөлбөрт Монголбанкыг оролцуулсан болон засгийн газрын бондын орлогыг хэрхэн ашиглах нь тодорхойгүй байгаа зэрэг нь ТТБТХуулийг зөрчих байдлыг улам нэмэгдүүлж байна.

- **Засгийн газрын үнийг тогтворжуулах арга хэмжээнд Монголбанк нь хөнгөлөлттэй санхүүжилт үзүүлэх байдлаар оролцох нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын уламжлалт үүргээс хол зөрсөн байдал юм.** Төв банкны үүрэг энэ хөтөлбөрт тодорхойгүй байх нь эцэстээ засгийн газрын хөтөлбөрийг төв банкны хямд санхүүжилтийн эх үүсвэрт найдсан хэрэгсэл болгон хувиргах талтай. Хэрвээ уг хөтөлбөрийн санхүүжилт дараагийн жилээс хэрэгжиж эхэлбэл уг хөтөлбөрөөс үүдэлтэй төсвийн нийт дарамт ДНБ-ий 4 хүртэл хувьд хүрэх юм. Төв банк Засгийн газрын уг

[9] Энэ нь ОТ дахин хэлэлцээрээс олох нэмэлт орлогын хэмжээ болон ОУВС Мэргэжилтнүүдийн Тайлангийн тооцоолсон орлогын хэмжээнд дээр үндэслэгдсэн.

[10] МУХБанкны 2013 оны жилийн зарлагын төлөвлөгөө нь тодорхойгүй. Энэхүү үнэлгээг ОУВСангийн Мэргэжилтнүүдийн Тайлангийн (2012 оны 12 сар) таамаглал дээр үндэслэн хийсэн бөгөөд үүнд МУХБ нь 2013-2016 онуудад жил бүр 500 сая засгийн газрын баталгаатай бондыг зарцуулна гэж үзжээ.

хөтөлбөрийн гол санхүүжүүлэгч байхаасаа татгалзах тодорхой стратегаа зарлах хэрэгтэй бөгөөд уг хөтөлбөрийн өртөгийг төсөвт зохих ёсоор суулгах ёстой.

- **Хэдийгээр дэлхийн санхүүгийн зах зээл дээр Монгол Улсын эдийн засгийг сонирхох байдал нэмэгдэж байгаа боловч засгийн газрын бондын орлогыг хэрхэн зөв зарцуулах төлөвлөгөө байхгүйгээр шинээр гаргасан бонд нь төсвийн томоохон эрсдэл үүсэх болно.** Одоогийн гаргасан 1.5 тэрбум ам.долларын (ДНБ-ий 11-12 хувьтай тэнцэх) засгийн газрын бондын орлогыг хэрхэн ашиглах болон бүртгэх талаар тодорхой төлөвлөгөө байхгүй бол Засгийн газар үүнийг төсвийн гадуурх санхүүжилтийн хэрэгсэл болгон ашиглах арга замыг хайхад хүргэнэ. Засгийн газрын бондыг гаргах танилцуулгын явцад уг орлогыг дэд бүтцийн төслүүдийг (өрөөр болон/эсвэл үндсэн хөрөнгийг оролцуулан) санхүүжүүлэхэд хэрэглэхээ зарласан. Түүнчлэн Засгийн газар уг орлогыг нэгдсэн төсвийн эсвэл нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд хэрэглэхгүй гэдгээ мэдэгдсэн. Засгийн газар дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхдээ МУХБанкаар дамжуулан ашиглах арга замуудыг хайх талтай. Өмнөх хэсэгт дурьдснаар, орлогыг хүлээн авах болон ашиглахад Засгийн газар хэрхэн яаж хэрэглэхээ төлөвлөхөөс үл хамааран төсөвт зөв тусгах ёстой: засгийн газрын үйл ажиллагааны шууд зардал байдлаар эсвэл МУХБанкинд зээлүүлэх байдлаар аль ч нь байсан төсөвт тусгагдах ёстой.

- **Засгийн газрын бондын орлогын ашиглалтыг төлөвлөхдөө, Засгийн газар эдийн засгийн шингээх чадвар, засгийн газрын удирдлагын чадавхи зэргийг тооцоолон төслүүдийг сонгох, үнэлэхэд хангалттай хугацаа гаргаж, анхааралтай хандах шаардлагатай.** Зарцуулалтыг хөнгөвчлөх, шалавлах тал дээр улс төрийн хүчтэй дарамт ирэх нь бараг тодорхой. Гэвч энэ орлогыг яарсан, хуумгай байдлаар зарцуулбал дараах байдлаар нөлөөлнө: (i) төсвийн тэлсэн төлөв байдлыг нэмэгдүүлэх болон эдийн засгийн дотоод/гадаад тэнцвэргүй байдлыг даамжруулна, мөн (ii) сайтар бэлтгэгдээгүй болон улс төрийн зорилготой төслүүдийг оруулах. Хэрвээ бүх орлогыг 2013 онд хөрөнгө оруулалтад хэрэглэнэ гэж үзвэл дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг 2012 оныхоос бараг хоёр дахин нэмэгдүүлэх бөгөөд дотоодын хөрөнгө оруулалтын ДНБ-д харьцах харьцаа 23 гаруй хувьд хүрнэ. Төсвийн болон макро эдийн засгийн байдалд томоохон нөлөөтэй байдлыг харгалзан, бондын хөрөнгөөр санхүүжигдэхээр шинээр орж байгаа аливаа төслийг төслийн сонголт, үнэлгээний үйл явцаар нямбай хянах ёстой. Гадаад валютаар хийгдсэн ийм хэмжээний зээл, болон санхүүгийн өртөгийг төсөв эргээд төлөх тул бондын орлогоор санхүүжигдэх төслүүд нь өртөгөө хангалттай нөхөх орлого бий болгох төслүүд байх ёстой.

Шигтгээ 1. 2012 оны гүйцэтгэл болон 2013 оны Төсвийн төсөөлөл

Төсвийн 1 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх төсвийн урьдчилсан гүйцэтгэлийн тоон мэдээлэл (Үндэсний Статистикийн Хороо) дээр үндэслэн 2012 оны гүйцэтгэлийн таамаглалаас харахад 2012 оны 9 дүгээр сард хийсэн хоёрдахь төсвийн тодотголын төсвийн орлогын таамаглал нь нэлээд өөдрөг байсан байна. Эхний 11 сарын байдлаар, төсвийн орлого төлөвлөсөн орлогын 78 хувьд хүрсэн бөгөөд зарлагын гүйцэтгэл нь төлөвлөсөн төсвийн 80 хувьд хүрсэн байна. Хэрвээ 12 дугаар сард орлого болон зарлагын хэмжээг 2007-2011 оны туршид гарсан гүйцэтгэлтэй адил хандлагатай байна гэвэл 2012 оны нийт орлогын тасалдал нь ДНБ-ий 2.7 хувиар тасарна. Хэрвээ нийт зарлагын гүйцэтгэл 2012 оны төсвийн 95 хувьд хүрнэ гэвэл улсын нэгдсэн төсвийн нийт алдагдал 2012 онд 5 хувьд хүрэхээр гарч байна.

2013 онд нийт орлого нь ДНБ-ий 6 хувь орчмоор буурахаар төлөвлөгдсөн байхад урсгал зардлын хэмжээ орлого буурснаас үүдэж буурч тооцоологдсон. Гэвч нэмж орж ирж байгаа зарлагын хоёр бүрэлдэхүүн хэсэг (Үнийг Тогтворжуулах Хөтөлбөр болон саяхны 1.5 тэрбум ам.долларын бондын орлогыг ашиглах) нь зардлын тохируулгыг буцаад тэнцвэржүүлж байна: хоёр бүрэлдэхүүн хэсгүүдээс үүдэх нэмэлт зарлага нь 2013 онд ДНБ-ий 4 гаран хувьтай тэнцүү байхаар байгаа бөгөөд энд Үнийг Тогтворжуулах Хөтөлбөрийн нийт өртөгийн гуравны нэг нь зөвхөн 2013 онд хэрэгжинэ мөн бондын орлогын дөрөвний нэг нь Засгийн газрын шинэ шууд хөрөнгө оруулалт байдлаар эсвэл МУХБанкинд зээлдүүлнэ гэж үзлээ. Эдгээр таамаглал дээр үндэслэвэл, төсвийн нийт алдагдал 6 хувиас илүү гарахаар байгаа ба төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал нь 7 хувиас илүү гарч байгаа нь ТТБТХуульд заасан хязгаарыг зөрчихөөр байна. Гэхдээ төсвийн төлөв байдлийн энэхүү төсөөлөл нь цаг хугацааны шинжтэй бөгөөд Засгийн газар хэрхэн тэргүүлэх чиглэлээр нь ангилах, зарлагыг бууруулан тохируулах, шинэ зарлагын бүрэлдэхүүн хэсгүүдийн хэдий хэсгийг нь 2013 онд хэрэгжүүлэх вэ зэрэг шийдвэрүүдээс ихээхэн хамаарна

Хүснэгт 5. Төсвийн гол үзүүлэлтүүдийн төлөв байдал

	2012		2013	
	Төсөв	Урьдчилсан гүйцэтгэл[1] (мэргэжилтнүүдийн төсөөлөл)	Төсөв (их наяд төгрөг)	Мэргэжилтнүүдийн төсөөлөл (их наяд төгрөг)
Нийт орлого	5.6	5.2	7.3	6.1[2]
Тэнцвэржүүлсэн орлого	5.5	5.1	7.1	5.9
Засгийн газрын зарлага	6.3	6.0	7.4	7.2[3]
Тэнцвэржүүлсэн тэнцэл(ДНБ-д эзлэх %)	(4.8%)	(5.6%)	(2.0%)	(7.6%)
Нийт тэнцэл (ДНБ-д эзлэх%)	(4.2%)	(5.0%)	(1.1%)	(6.6%)

Эх үүсвэр: Сангийн яам, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн төсөөлөл, ОУВСангийн Мэргэжилтнүүдийн Тайлан (2012 оны 11 сар)

1 2012 оны гүйцэтгэл нь 2012 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх жинхэнэ гүйцэтгэл болон 2007-2011 онуудын туршид 12 дугаар сарын орлого, зарлагын хандлагыг үндэслэн тооцсон.

2 2013 оны орлогын төсөөллийг ОУВСангийн Мэргэжилтнүүдийн Тайлангийн төсөөлөл (2012 оны 11 сар) болон ОТ дахин хэлэлцээрээс нэмэлт орлого бий болохгүй гэж таамаглалаа.

3 Засгийн газрын зардлын төсөөллийг хийхдээ 2013 оны төсвийн урсгал зардлыг 10 хувиар бууруулна гэж үзээд Үнийг Тогтворжуулах Хөтөлбөр болон 1.5 тэрбум ам.долларын бондын орлогын ашиглалтыг нэмэлт зарлага болно гэж үзлээ. Мөн Үнийг Тогтворжуулах Хөтөлбөрийн нийт өртөгийг (718 сая төгрөг) гэж үзээд түүнийг дараагийн гурван жилд жигд хуваарилах, мөн 1.5 тэрбум ам.долларын орлогын зөвхөн дөрөвний нэг нь засгийн газрын зардлын шинэ хөтөлбөр эсвэл 2013 оны цэвэр зээллэгт хэрэглэгдэнэ гэж үзлээ. Өөр нэг хувилбар нь хэрвээ 2013 оны урсгал зардлыг 100 хувь хэрэгжинэ гэвэл нэмэлт хоёр зардлын бүрэлдэхүүнээс үүсэх нэмэлт зардлын таамаглал хэвээрээ үед нийт алдагдал ДНБ-ий 12 хувь хүрэхээр байна.

Хавсралт: 2013 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд

	Тэрбум төгрөг			ДНБ-д эзлэх хувь			2013 Төсөв (өөрчлөлт %)
	2011 гүйцэтгэл	2012 тодотгол	2013	2011 гүйц	2012 тод	2013	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	**4,468,198.0**	**5,631,686.9**	**7,258,092.4**	**40.3**	**34.9**	**41.1**	**28.9**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**4,227,178.1**	**5,530,336.9**	**7,088,333.7**	**38.1**	**34.3**	**40.2**	**28.2**
Татварын орлого	**3,668,307.8**	**4,925,603.9**	**6,461,531.6**	**33.1**	**30.5**	**36.6**	**31.2**
Орлогын татвар	833,738.9	950,859.7	1,261,481.6	7.5	8.2	5.9	32.7
ХАОАТ	232,257.3	292,182.2	397,727.5	2.1	1.8	2.3	36.1
ААНОАТ	545,631.1	658,677.5	863,754.0	4.9	4.1	4.9	31.1
Нийгмийн даатгалын шимтгэл	473,351.3	591,565.0	732,018.1	4.0	4.7	3.7	23.7
Борлуулалтын татвар ба НӨАТ	1,114,382.5	1,734,053.0	1,940,163.9	11.0	11.0	10.7	11.9
Онцгой татвар	293,967.0	376,367.5	595,227.5	3.0	2.9	2.3	58.2
Гадаад худалдааны татвар	337,422.6	565,955.9	575,299.6	3.5	3.3	3.5	1.7
Бусад татварууд	662,859.7	1,296,310.9	633,451.2	5.1	5.6	4.1	95.6
Нөөц ашигласны төлбөр	204,921.7	291,646.4	367,329.4	1.8	1.8	2.1	26.0
Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	177,785.2	193,365.1	199,035.1	1.6	1.2	1.1	2.9
Татварын бус орлого	**545,366.5**	**602,915.0**	**625,986.5**	**4.9**	**3.7**	**3.5**	**3.8**
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**4,997,040**	**6,312,220.3**	**7,444,625.0**	**45.1**	**39.1**	**42.2**	**17.9**
УРСГАЛ ЗАРДАЛ	**3,236,403**	**4,606,347.5**	**4,906,137.0**	**29.2**	**28.6**	**27.8**	**6.5**
Цалин хөлс	802,465	1,220,856.9	1,406,241.5	7.2	7.6	8.0	15.2
Бусад бараа үйлчилгээ худалдан авах	702,040	870,752.0	1,072,066.4	6.3	5.4	6.1	23.1
Татаас шилжүүлэг	**1,694,577**	**2,363,149.3**	**2,028,389.1**	**15.3**	**14.6**	**11.5**	**(14.2)**
Татаас	122,881	119,232.8	185,993.3	1.1	0.7	1.1	56.0
Шилжүүлэг	1,571,697	2,243,916.5	1,842,395.8	14.2	13.9	10.4	(17.9)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**1,280,920**	**1,719,710.4**	**2,488,859.6**	**11.6**	**10.7**	**14.1**	**44.7**
Дотоодын хөрөнгө оруулалт	1,020,970	1,408,993.0	2,008,220.0	9.2	8.7	11.4	42.5
Хөрөнгийн засвар	50,139	55,776.9	51,875.4	0.5	0.3	0.3	(7.0)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ (%)	**(769,862)**	**(781,883.4)**	**(356,291.3)**	**(6.9)**	**(4.8)**	**(2.0)**	**(54.4)**
НИЙТ ТЭНЦЭЛ (%)	**(528,841.8)**	**(680,533.4)**	**(186,532.6)**	**(4.8)**	**(4.2)**	**(1.1)**	**(72.6)**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**241019.89**	**101350.00**	**169,758.7**	**2.2**	**0.6**	**1.0**	**67.5**

Эх үүсвэр: Сангийн яам (2013 оны төсөв), Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо